

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДАГЛАМЖИЙН ТӨВ ХХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТОДРУУЛГАД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/92/-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885

Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор П.Амарсанаа

Утас: 261740

Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн

Захирал С.Тунгалаг

Утас: 70001778

Цахим хаяг: tungalag.s@imkaudit.mn

Чанарын хяналтын мэргэжилтэн: С.Сожидмаа

Утас 70001778

Цахим хаяг: sojidmaa.s@imkaudit.mn

Аудитор: Д.Пүрэвжаргал

Утас: 70001778

Цахим хаяг: purvjargal.d@imkaudit.mn

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	<i>Санхүүгийн тайлангийн талаар</i>	4
2.9.2	<i>Үндсэн хөрөнгийн талаар</i>	4
2.9.3	<i>Орлогын талаар</i>	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	4
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	5
3	Менежментийн захидал.....	6
	Асуудал 1: Үндсэн хөрөнгийн талаар.....	7
	Асуудал 2: Орлогын талаар	8
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшин.....	9
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	10
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	11
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.5	Аудит хийгдсэн орлого, зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан.....	13

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулгад, санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу, тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн захирал Ш.Лхагва танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар үнэт цаасны компаниудад харилцагчдыг үлдэгдлийг харах нэгдсэн системтэй болгох асуудлын талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн удирдлага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн жилийн эцсийн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 06-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 09-нд эцэслэн баталгаажуулж, Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн захиралд хүргүүлэхээр төлөвлөн, “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн аудитор Д.Буянравжих, аудиторын туслах Т.Оюун, гэрээт ажилтан Н.Болормаа, аудиторын туслах М.Батжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 01/309 дугаар албан бичгээр “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн, Компанийн, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны, Үнэт цаасны, Төрийн болон орон нутгийн өмчийн, Нягтлан бодох бүртгэлийн болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Сангийн сайдын 2014 оны 249 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан гэрээ, зорилтот түвшний үзүүлэлтийг ханган биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, өөрийн орлогоор зардлаа санхүүжүүлэн ажилладаг.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн эрхэм зорилго нь: Үнэт цаасны хадагламж, өмчлөх эрх, бүртгэлийн аюулгүй найдвартай байдлыг ханган олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг үзүүлнэ.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Хадагламжийн мэдээллийн сангийн цогц үйлчилгээг өргөжүүлэх, үнэт цаасны бүртгэлийн найдвартай байдлыг хангах, бизнесийн орчин болон дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн өөрчлөлтөд нягт оролцож, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогчдод зориулан хөрөнгийн зах зээлийн үйлчилгээг сайжруулан, байнгын өөрчлөлт шинэчлэлт хийхэд оршино.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Монгол Улсад үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн үйлчилгээ эрхлэх, биржийн болон биржийн бус арилжааны өмчлөх эрх шилжүүлэх, төвлөрсөн хадагламж дахь мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, олон улсын жишгийн дагуу кастодиан үйлчилгээ эрхлэх юм.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн


Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 13 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 41 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн санхүүгийн аудит ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн



технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулсан нягтлан бодох бүртгэлийн “Solarsys” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “хэвийн” гэж үзлээ.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн дотоод хяналт шалгалтын журмыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 07 дугаар сарын 05-ны тогтоолоор баталсан байна. Дотоод хяналт шалгалтын нэгжээс 2017 онд дотоод хяналт шалгалтыг хийж 1 зөрчил илрүүлэн, биелэлтийг шалгаж зөрчлийг арилгуулсан байна.

2.6 Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот төвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсныг 2017 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор тодотгол хийж 1,711.9 сая төгрөгийн орлого, 1,064.5 сая төгрөгийн зардалтай, 620.3 сая төгрөгийн цэвэр ашигтай, 27.0 сая төгрөгийн орлогын албан татвар төлөхөөр баталсан байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн тайлант онд 1,939.7 сая төгрөгийн нийт орлого (үүнээс 1,241.9 сая төгрөгийн)-той, 1,027.2 сая төгрөгийн зардалтай, 897.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 14.2 сая төгрөгийн орлогын албан татвар төлсөн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4 дүгээр бүлэгт заасны дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад, оруулах шаардлагатай 7 төрлийн мэдээллээс худалдан авах ажиллагааны тайлангаас бусад мэдээллийг бүрэн байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 41 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.



2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Санхүүгийн тайлангийн талаар

- Санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн ашиг алдагдал, өмчийн өөрчлөлтийн тайлан, санхүүгийн байдлын тайлангийн хуримтлагдсан ашиг алдагдал нь 6.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулж тайлагнав.

2.9.2 Үндсэн хөрөнгийн талаар

Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг санхүүгийн програмд гараар оруулж элэгдлийг тооцож байгаа нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

2.9.3 Орлогын талаар

Арилжааг нь сэргээсэн сэргээсэн боловч үйл ажиллагаа явуулаагүй 19 компанийн хураамжийг төвлөрүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрэль сууриар хөтөлнө” гэж заасныг, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд бусад санхүүгийн хөрөнгө 6,191.9 сая төгрөг, урт хугацаат хөрөнгө оруулалт 5,759.0 сая төгрөг нөөц өр төлбөр 100.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, эзэмшигчдийн өмч 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.


Энэ нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар тогтоолоор Засгийн газрын 6,091.0 сая төгрөгийн богино хугацаат бонд, 2017 оны 05 дугаар сарын 07 дугаар тогтоолоор 3,058.9 сая төгрөгийн урт хугацаат бондыг тус тус худалдан авсан байна.

Компанийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөнөөс 2,700.0 сая төгрөгийг Төрийн банканд 2 жилийн хугацаатай хадагламжийн гэрээ байгуулан байршуулсан байна.

Төрийн банкны 1 жилийн хугацаатай 100.0 сая төгрөгийн хадгаламжийн сертификат худалдан авсан, Сангийн яамнаас 1,000.0 төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлсэн зэргээс дээрхи хөрөнгүүд нэмэгдсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 08 тоот тогтоолоор “Эрсдэлийн санг үүсгэн байгуулах, захиран зарцуулах журам”-ыг баталсны дагуу 100.0 сая төгрөгийн эрсдлийн санг байгуулсан байна.

Өмнөх аудитын тайлангаар төвлөрсөн хадагламжинд данстай харилцагчдын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тул хязгаарлалттай дүгнэлт өгч байсан байна.



Нийт 284904 харилцагчдын үлдэгдлийг баталгаажуулах талаар үнэт цаасны компаниудтай гэрээ байгуулах, компанийн төвлөрсөн хадагламжийн интернет банкны үйлчилгээ үзүүлэх, регистрийн дугаараар данстай эсэхээ шүүх, харилцагчид өөрийн биеэр дансны хуулгаа авах зэрэг үйлчилгээг авч хэрэгжүүлсэн байна.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар үнэт цаасны компаниудад харилцагчдыг үлдэгдлийг харах нэгдсэн системтэй болгох асуудлыг дахин хянаж үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 6.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс:

Нийт 6.5 сая төгрөгийн алдааг залруулж, 2 зөрчилд зөвлөмж өгөв.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 18 зөвлөмж өгснөөс 16 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 7 дугаар заалттай нийцээгүй 2 зөвлөмжийг хэрэгжүүлэх шатандаа байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн үе шатанд орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,042.4 сая төгрөгийн 1 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,042.4 сая төгрөгийн 1 хувь буюу 10.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, НББОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төв ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



Асуудал 1: Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол ᠒1

Ажиглалт

Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг санхүүгийн программд гараар оруулж элэгдлийг тооцож байна. Энэ нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж

Үндсэн хөрөнгийн элэгдлийг программд тохируулан тооцож байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Орлого буруу илэрхийлэгдэх, байгууллагын эдийн засгийн үр дүнг бодитой илэрхийлэхгүй байх.

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 2: Орлогын талаар

Тэргүүлэх ач холбогдол 2

Ажиглалт

Арилжааг нь сэргээсэн сэргээсэн боловч үйл ажиллагаа явуулаагүй 19 компанийн хураамжийг төвлөрүүлэх арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1-д " Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрэль сууриар хөтөлнө" гэж заасныг, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна..

Зөвлөмж

Үйл ажиллагаа нь зогссон боловч бүртгэлтэй, хураамж төлөөгүй компаниудын талаар эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэхгүй байх

/ЭҮ,ТТ, ИБ, ҮХ, ҮЗ, /

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшин

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,870,842,876.86	588,396,464.36
Дансны авлага	2,050,000.00	11,133,032.41
Татвар, НДШ-ийн авлага	54,765.91	-
Бусад авлага	141,752,613.49	162,566,360.79
Бусад санхүүгийн хөрөнгө	-	6,191,927,342.22
Бараа материал	26,516,883.05	25,794,381.05
Урьдчилж төлсөн зардал /Тооцоо/	28,076,346.52	23,947,437.65
Эргэлтийн хөрөнгийн дүн	11,069,293,485.83	7,003,765,018.48
Үндсэн хөрөнгө	1,471,081,475.27	1,638,734,561.62
Биет бус хөрөнгө	22,421,414.32	14,911,460.51
Уртхугацаат хөрөнгө оруулалт	-	5,758,978,715.12
Хойшлогдсон татварын хөрөнгө	889,577.30	3,663,057.37
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,494,392,466.89	7,416,287,794.62
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,563,685,952.72	14,420,052,813.10
Дансны өглөг	630,539.57	5,750,000.00
Татварын өглөг	5,137,301.14	866,442.85
НДШ-ийн өглөг	267,659.06	-
Урьдчилж орсон орлого	11,676,805.00	3,416,067.09
Бусад богино хугацаат өр төлбөр	10,511,934,249.16	10,386,392,628.31
Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,529,646,553.93	10,396,425,138.25
Нөөц /өр төлбөр/	-	100,000,000.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	100,000,000.00
Өр төлбөрийн дүн	10,529,646,553.93	10,496,425,138.25
Өмч Төрийн	2,000,000,000.00	3,000,000,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	98,723,938.00
Хуримтлагдсан ашиг	34,039,398.79	824,903,736.85
Эздийн өмчийн дүн	2,034,039,398.79	3,923,627,674.85
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,563,685,952.72	14,420,052,813.10



4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого	573,695,552.39	694,275,099.19
Борлуулалтын өртөг	208,149,331.93	277,379,490.06
Нийт ашиг/алдагдал	365,546,220.46	416,895,609.13
Хүүгийн орлого	154,789,040.86	1,241,948,718.97
Бусад орлого	914,891.00	3,463,091.01
Ерөнхий ба удирдлагын зардал	460,257,988.65	736,160,839.42
Бусад зардал	11,519,001.21	13,684,615.35
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз	45,140.42	(769,595.08)
Бусад ашиг /алдагдал	-	(62,131.00)
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	49,518,302.88	911,630,238.26
Орлогын албан татвар	15,478,904.09	14,217,137.57
Татварын дараах ашиг/алдагдал	34,039,398.79	897,413,100.69



4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,000,000,000.00	-	-	2,000,000,000.00
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	34,039,397.79	34,039,397.79
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
2016 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,000,000,000.00	-	34,039,398.79	2,034,039,398.79
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	897,413,200.00	897,413,200.0
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	3,663,000.00	3,663,000.00
Өмчид гарсан өөрчлөлт	1,000,000,000.00	-	(100,000,000.00)	900,000,000.0
Зарласан ногдол ашиг	-	-	10,211,898.79	10,211,898.79
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	98,723,938.00	-	98,723,938.0
2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	3,000,000,000.00	98,723,938.00	824,903,700.00	3,923,627,638.00



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
Мөнгөн орлогын дүн	790,098,857,025.46	357,841,481,316.41
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	594,176,569.20	688,415,966.28
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	7,322,515.00	18,995,086.00
Татаас санхүүжилтийн орлого	323,612,315.17	1,000,000,000.00
Бусад мөнгөн орлого	789,173,745,626.09	356,134,070,264.13
Мөнгөн зарлагын дүн	789,695,002,919.59	357,261,154,755.12
Ажиллагчдад төлсөн	312,326,369.86	512,129,757.56
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	75,530,921.81	123,435,138.19
Бараа материал авахад төлсөн	16,323,162.71	18,441,989.00
Ашиглалтын зардалд төлсөн	8,734,060.12	30,481,093.58
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,150,000.00	3,746,100.00
Татварын байгууллагад төлсөн	68,081,681.00	94,212,869.44
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	1,673,010.00	350,200.00
Бусад мөнгөн зарлага	789,211,183,714.09	356,478,357,607.35
Үндсэн үйл ажиллагааны цэвэр монгон гүйлгээний дүн	403,854,105.87	580,326,561.29
Мөнгөн орлогын дүн	154,939,040.86	7,033,234,678.80
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	150,000.00	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	6,221,631,516.70
Хүлээн авсан хүүний орлого	154,789,040.86	811,603,162.10
Мөнгөн зарлагын дүн	57,000,280.00	17,895,547,743.98
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	57,000,280.00	165,367,075.00
хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	17,730,180,668.98
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	97,938,760.86	(10,862,313,065.18)
Мөнгөн орлогын дүн	-	-
Мөнгөн зарлагын дүн	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Валютын ханшны зөрүү	45,140.42	(459,908.61)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	501,792,866.73	(10,282,446,412.50)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,369,004,869.71	10,870,842,876.86
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,870,797,736.44	588,396,464.36



4.5 Аудит хийгдсэн орлого, зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	2016 он	2017 он		Төлөвлөгөөнөөс	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
А	Б	В	Г	Д	Е
Үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний орлого	61,293.90	251,134.3	370,851.5	119,717.2	148%
Үнэт цаасны өмчлөх эрх бүртгэлийн орлого	496,031.50	294,043.2	297,699.1	3,655.9	101%
Кастодианы үйлчилгээний орлого	3,627.10	6,000.0	6,000.0	-	100%
Бусад орлогын дүн	168,800.30	1,160,708.5	1,265,136.3	104,427.8	109%
Нийт орлого	729,752.80	1,711,886.0	1,939,686.90	227,800.90	113%
Нийт зардал	680,234.50	1,064,541.9	1,028,056.70	(36,485.20)	97%
Үүнээс: Удирдлагын зардал	71,043.10	66,584.3	65,533.70	(1,050.60)	98%
Татварын өмнөх ашиг/ алдагдал/	49,518.30	647,344.1	911,630.20	264,286.10	141%
Цэвэр ашиг/ алдагдал/	34,039.40	620,310.2	897,413.1	277,102.90	145%
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-
Борлуулалтын 1 төрөгт ногдох зардал	0.93	0.62	0.53	(0.09)	85%
Нийт авлага	143,857.40	142,659.8	173,699.4	31,039.60	122%
Нийт өр төлбөр	17,744.10	21,500.0	10,044.5	(11,455.50)	47%
Үүнээс Богино хугацаат өр төлбөр	17,744.10	21,500.0	10,044.5	(11,455.50)	47%
Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт	57,000.30	222,037.0	165,367.1	(56,669.90)	74%
Нийт ажиллагсдын тоо	37.00	39	40	1.00	103%
Нийт цалин сан	382,097.00	574,562.6	570,187.1	(4,375.50)	99%

